



**ОРХОН АЙМГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ТОГТООЛ**

2019 оны 05 сарын 08 өдөр

Дугаар 40


Эрдэнэт

Г Дэд хөтөлбөр батлах тухай Т

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.1 дэх хэсэг, 18 дугаар зүйлийн 18.1.2 “ж”, 19 дүгээр зүйлийн 19.1 дэх заалт, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Ээлжит III дугаар хуралдааны 01 дүгээр тогтоолын 8 дугаар бүлгийн 8.7.3 дах заалтыг тус тус үндэслэн аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

1.“Өндөр ёс зүйтэй-Өөдрөг иргэд” аймгийн дэд хөтөлбөрийг нэгдүгээр, хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг хоёрдуугаар хавсралтаар тус тус баталсугай.

2.Хөтөлбөр, төлөвлөгөөг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулж, шаардагдах хөрөнгийн эх үүсвэрийг жил бүрийн улс, орон нутгийн төсөвт тусган батлуулж, биелэлтийн явц, үр дүнг жил бүрийн 3 дугаар сард багтаан аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдэд танилцуулж байхыг аймгийн Засаг дарга Д.Батлутад даалгасугай.



0010078